

ГАРЧИГ

1.	Нийтлэг үндэслэл	2
2.	Зорилго	4
3.	Хамрах хүрээ	4
4.	Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ	6
5.	Гамшгаас хамгаалах шуурхай штаб, шуурхай бүлгийн бүрэлдэхүүний томилгоожилт.....	5
6.	Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах арга хэмжээ.....	6
7.	Газар хөдлөлтийн гамшгийн үеийн шуурхай удирдлага, зохион байгуулалт.....	8
8.	Зарлан мэдээлэл, холбоо зохион байгуулалт.....	10
9.	Нөөцийн.....	11
10.	Хангалт зохион байгуулалт.....	11
11.	Нүүлгэн шилжүүлэх.....	12
12.	Хавсралтууд	12

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол орны нутаг дэвсгэрт 2019 онд 30100, хил орчмын бүсэд 15657 газар хөдлөлт болж Монгол орны нутаг дэвсгэр болон хил орчмын бүс нутагт нийт 45757 газар хөдлөлт болсон.

Үүнээс Улаанбаатар хот орчмын нутаг дэвсгэрт тохиолдож буй газар хөдлөлтийн статистик мэдээллийг харахад (46.5-49.5N, 104.8-109.8E) 2005 он хүртэл жилд дунджаар 200 орчим газар хөдлөлт бүртгэгддэг байсан бол 2005 оноос 2-3 дахин, 2012 онд 4 дахин, 2013 онд 10 дахин их болж өссөн, 2019 оны байдлаар 1010 газар хөдлөлт болсон нь газар хөдлөлтийн идэвхжилт буурахгүй байна.

2013 онд Онцгой байдлын ерөнхий газар, Япон Улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн “Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлээс хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд хийсэн Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээгээр 6.6 болон түүнээс дээш магнитудын хүчтэй газар хөдлөлт хотын баруун талд Эмээлт, Хустайн нуруу, зүүн талд Гүнжийн аманд илэрсэн идэвхтэй хагарлууд дээр болж болзошгүй бөгөөд эдгээр хагарлуудад голомттой газар хөдлөлт болоход Улаанбаатар хотын барилга байгууламжийн 22-50 хувьд нуралт, эвдрэл, гэмтэл үүсэж, 30.000-60.000 орчим хүн нэрвэгдэх тооцоо гарсан.

Одон орон, геофизикийн хүрээлэнгээс Улаанбаатар хотын болон алслагдсан 3 дүүргийн газар нутгийн газар хөдлөлтийн бичил мужлалын зургийг 2015 онд шинэчлэн боловсруулсан бөгөөд уг зургаар Онцгой байдлын ерөнхий газрын барилга нь 8 баллын мужлалт бүхий газарт байрлаж байна.

1.2. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг Гамшгаас хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг урьдчилан сэргийлэх, аврах хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөө”, Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт “Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам”, 2 дугаар хавсралт “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”, Засгийн газрын 2018 оны 67 дугаар тогтоол “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам”, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн даргын 2011 оны 08 дугаар захирамжаар батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө”, Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах улсын албадын гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”, “Аймаг, нийслэлийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”, Шадар сайдын 2018 оны

125 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар” нь энэхүү төлөвлөгөөний эрх зүйн үндэслэл болно.

1.3. Энэхүү төлөвлөгөө нь

- Нийтлэг үндэслэл
- Зорилго
- Хамрах хүрээ
- Гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ
- Улсын онцгой комиссын шуурхай штаб, шуурхай бүлгийн бүрэлдэхүүний томилгоожилт
- Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах арга хэмжээ
- Шуурхай удирдлага зохицуулалт
- Зарлан мэдээлэл, холбоо зохион байгуулалт
- Дайчилгааны төлөвлөгөө
- Нөөц бүрдүүлэлт
- Хангалт зохион байгуулалт
- Нүүлгэн шилжүүлэх тооцоо гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

1.4. Төлөвлөгөөг жил бүрийн нэгдүгээр улирал болон шаардлагатай үед Гамшгийн шуурхай удирдлагын газрын газар хөдлөлтийн тасаг хариуцан тодотгоно.

Хоёр. Зорилго

2.1. Газар хөдлөлтийн гамшгийн үед Онцгой байдлын ерөнхий газрын ажиллах төлөвлөгөөний зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт тохиолдсон газар хөдлөлтийн гамшгийн үед шуурхай ажиллагааг зохион байгуулах, зарлан мэдээллийг хүргэх, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах, шуурхай удирдлагын суурин болон хөдөлгөөнт байрыг төхөөрөмжлөх, холбоо зохион байгуулах, харилцан ажиллагааг хангах, уялдуулан зохицуулах, хүч хэрэгслийг тасралтгүй удирдан зохион байгуулахад оршино.

Гурав. Хамрах хүрээ

3.1. Онцгой байдлын ерөнхий газрын төв байр, өргөтгөлийн байр, тавиулан, Гамшиг судлалын хүрээлэнд үйл ажиллагаа явуулж буй алба хаагчид болон ажилтнуудад хамаарна.

Дөрөв. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ

4.1. Онцгой байдлын ерөнхий газрын үндсэн барилга нь 4 давхар, өрөгт бүтээцтэй, тоосгон барилга бөгөөд 1971 онд ашиглалтад орсон. Уг барилга нь анх

инженерийн судалгаа хийгдэж, газар хөдлөлтийн 7 баллын чичирхийлэлт тэсвэрлэх чадвартай баригдсан.

4.2. Газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварын үнэлгээг 2012 онд хийлгэхэд 7 баллаас 6 балл хүртэл буурч, дотор даацын ханануудыг хүчитгэн цаашид ашиглах боломжтой гэсэн дүгнэлт гарсан (Барилгын үнэлгээний материалыг 1 дүгээр хавсралтаар хавсаргав). Үндсэн болон туслах хийцэд хүчитгэл хийгдээгүй, 2010 онд их засвар хийгдсэн. Эмзэг байдал эрсдэлийн үнэлгээг /хавсралт 1/ хийлгэсэн.

4.3. Онцгой байдлын ерөнхий газрын өргөтгөлийн барилга нь 2015 онд ашиглалтад орсон, 4 давхар цутгамал араг бүтээцтэй, блокон дүүргэгч ханатай, газар хөдлөлтийн 8 баллын чичирхийлэлтийг тэсвэрлэх чадвартай баригдсан. Галын автомат дохиоллын системтэй, давхар бүрт галын гидранттай.

4.4. Өргөтгөлийн барилгад Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв, Онцгой байдлын албаны музей, Улсын Онцгой комиссын ажлын алба байрладаг.

4.5. Онцгой байдлын ерөнхий газрын үндсэн болон өргөтгөлийн барилгад өдрийн цагаар 124 алба хаагч, 15 ажилтан, шөнийн цагаар 4 алба хаагч, 2 ажилтан байнгын үүрэг гүйцэтгэдэг.

**Тав. Улсын онцгой комиссын шуурхай штаб,
шуурхай бүлгийн бүрэлдэхүүний томилгоожилт**

5.1. Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан газар хөдлөлтийн Гамшгаас хамгаалах шуурхай штаб, шуурхай бүлгийн бүрэлдэхүүн байгуулсан тушаалын хуулбар /хавсралт 2/, шуурхай штаб, шуурхай бүлгийн бүрэлдэхүүний холбогдох хаягийн бүртгэл /хавсралт 3/, шуурхай штабын ажиллах үүргийг /хавсралт 4/ хавсаргав.

Зургаа. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах арга хэмжээ

1. Гамшгийн өмнө: урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах арга хэмжээ

д/д	Авах арга хэмжээ	Хугацаа	Хариуцах бүлэг	Дэмжих бүлэг
1	Барилга байгууламжийн газар хөдлөлтөд тэсвэрлэх байдалд мэргэжлийн байгууллагаар үнэлгээ, хүчитгэл хийх, барилгын хийц бүтээцэд өөрчлөлт оруулахгүй байх	2020-2022	Шуурхай штаб	Эрэн хайх бүлэг
2	Байгууламжийн дотор, гадна талд аюул, эрсдэлийг тооцсон зураглал гаргах, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах.	3 жилд	Шуурхай удирдлагын штаб	Холбооны бүлэг
3	Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, өөртөө болон бусдад үзүүлэх анхны тусламжийн мэдлэг олгох сургалт, сурталчилгааг зохион байгуулах.	Жил бүр	Шуурхай удирдлагын штаб	Анхны тусламжийн бүлэг
4	Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх ажиллагаанд гамшгаас хамгаалах шуурхай	Жил бүр	Шуурхай удирдлагын	Эрэн хайх бүлэг

	штаб, шуурхай бүлгийн бүрэлдэхүүнийг сургаж дадлагажуулах.		штаб	
5	Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах, нүүлгэн шилжүүлэх дадлага сургууль зохион байгуулах.	Жилд 2 удаа	Нүүлгэн шилжүүлэх бүлэг	Холбооны бүлэг
6	Газар хөдлөлтийн үед цугларах аюулгүй талбай, нүүлгэн шилжүүлэх байрыг сонгож урьдчилсан бэлтгэлийг хангах, хүрэх замыг урьдчилан тогтоох	Улирал бүр	Нүүлгэн шилжүүлэх бүлэг	Санхүү, хангалт үйлчилгээний бүлэг
7	Хүн нэг бүрийн үүргэвчинд байх зүйлсийг бүрдүүлэх, шалгах.	Жил бүр	Шуурхай удирдлагын штаб	Эрэн хайх бүлэг
8	Аюул учруулж болзошгүй эд зүйлсийг сайтар бэхлэх арга хэмжээг авах.	Жил бүр	Эрэн хайх бүлэг	Ажиллагааны бүлэг
9	Аюулгүйн гарц, нөөц гарцын бүдүүвч зураг гаргаж, гарцыг чөлөөлөх.	Жил бүр	Нүүлгэн шилжүүлэх бүлэг	Санхүү, хангалт үйлчилгээний бүлэг

2. Гамшгийн үед: хариу арга хэмжээ авах

д/д	Авах арга хэмжээ	Хугацаа	Хариуцах бүлэг	Дэмжих бүлэг
1	Алба хаагчид болзошгүй газар хөдлөлтийн үед өрөө тасалгаан дотроо “Суу”, “Нуугд”, “Хүлээ” гэсэн зарчмын дагуу аюулгүй байдлаа хангах.	2 минут	Нүүлгэн шилжүүлэх бүлэг	Эрэн хайх бүлэг
2	Цахилгаан, дулааны шугам сүлжээг салгах аюулгүй болгох.	10 минут	Аюулгүй байдлын бүлэг	Тандан турших бүлэг
2	Гарц, хаалгыг бүрэн онгойлгох.	5 минут	Аюулгүй байдлын бүлэг	Нүүлгэн шилжүүлэх бүлэг
3	Чичирхийлэл зогссоны дараа байрлалаасаа гарч аюулгүй талбайд цугларах.	5 минут	Нүүлгэн шилжүүлэх бүлэг	Аюулгүй байдлын бүлэг
4	Нүүлгэн шилжүүлэх ажиллагааг зохион байгуулах.	3 цаг	Нүүлгэн шилжүүлэх бүлэг	Аюулгүй байдлын бүлэг
5	Түр цугларах талбайд гарч бүртгүүлнэ.	40 минут	Олон нийттэй харилцах бүлэг	Холбооны бүлэг
6	Гэмтэж бэртсэн алба хаагчдад яаралтай анхны тусламж үзүүлэх.	2 цаг	Анхны тусламжийн бүлэг	Эрэн хайх бүлэг
7	Гамшгаас хамгаалах шуурхай штаб, шуурхай бүлгийн бүрэлдэхүүнийг үүрэгжүүлэх.	5 минут	Шуурхай удирдлагын штаб	Эрэн хайх бүлэг
8	Хоёрдогч аюул үүсэхээс сэргийлэх, таслан зогсоох /гал түймэр, дэлбэрэлт, хөлдөлт, химийн хортой болон аюултай бодис алдагдах/ арга хэмжээ авах.	50 минут	Гал түймэр унтраах бүлэг	Аюулгүй байдлын бүлэг

9	Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн үүрэг гүйцэтгэж буй албан хаагчид үндсэн байрлалдаа аюулгүй байдлаа ханган үүрэг гүйцэтгэнэ. Газар хөдлөлтийн дараа барилгад ноцтой эвдрэл гэмтэл гараагүй тохиолдолд барилгад нэвтэрч болно.	30 минут	Эрэн хайх бүлэг	Нүүлгэн шилжүүлэх бүлэг
10	Байгууллагын туг, тамга, архивын нэн шаардлагатай материалыг нүүлгэн шилжүүлэх, аюулгүй газар байрлуулах ажлыг Захиргааны удирдлагын газар хариуцаж, Онцгой байдлын ерөнхий газрын Захиргаа удирдлагын газрын даргын 2018 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн баталсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.	50 минут	Нүүлгэн шилжүүлэх бүлэг	Эрэн хайх бүлэг

3.Гамшгийн дараах үе: хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаа

д/д	Авах арга хэмжээ	Хариуцах бүлэг	Дэмжих бүлэг
1	Гамшгаас хамгаалах шуурхай штаб, шуурхай бүлгийн бүрэлдэхүүн нөхцөл байдлын тайлан мэдээг гаргаж, штабын удирдлагад хүргүүлэх	Бүлэг бүр	Тандан турших бүлэг
2	Аврах ажиллагааны үед дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангах	Тандан турших бүлэг	Эрэн хайх бүлэг
3	Гамшгийн нөхцөл байдлыг үнэлэх	Тандан турших бүлэг	Эрэн хайх бүлэг
4	Нэрвэгдэгч болон нурсан хана, тааз, шатыг тодорхойлох, зам гарцын зураглал үйлдэх, хүн хүчний тооцоог гаргах	Тандан турших бүлэг	Эрэн хайх бүлэг
5	Хохирлыг тооцох, шаардлагатай засвар үйлчилгээг хийх	Эрэн хайх бүлэг	Олон нийттэй харилцах бүлэг
6	Ус, хоол хүнс, хоргодох байр, эм, боолт, ариутгалын хэрэгслийг тараана.	Анхны тусламжийн бүлэг	Харуул хамгаалалтын бүлэг
7	Мэргэжлийн аврах ангийн үйл ажиллагааг мэдээллээр хангаж аврах ажиллагаанд оруулах	Шуурхай удирдлагын штаб	Тандан турших бүлэг
6	Нэрвэгдэгсдэд анхны тусламж үзүүлэх	Анхны тусламжийн бүлэг	Тандан турших бүлэг
7	Шаардлагатай тохиолдолд дайчилгаа зохион байгуулах	Шуурхай удирдлагын штаб	Эрэн хайх бүлэг

Долоо. Шуурхай удирдлага зохицуулалт

7.1. Ажлын цагаар аюулгүй талбайд цугласан алба хаагчдыг нэгдсэн зохион байгуулалтад оруулан Ц+0.00-0.30 цагт Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2007 оны 508 дугаар тушаалаар баталсан “Гамшгийн нөхцөл байдал үүссэн үед

Онцгой байдлын ерөнхий газрын газар, хэлтсийн ажиллах журам"-ын дагуу үйл ажиллагааг зохион байгуулж эхэлнэ.

7.2. Газар хөдлөлтийн гамшгийн нөхцөл байдал үүссэн үед шуурхай бүлгийн бүрэлдэхүүнийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2008 оны 286 дугаар тушаалаар баталсан "Журам, заавар, бүлгийн бүрэлдэхүүн, жагсаалт батлах тухай" тушаалын 3 дугаар хавсралтад заасан "Шуурхай бүлгийн бүрэлдэхүүний томилгоо"-ны дагуу ажлын цагаар Ц+0.30 цагт, ажлын бус цагаар Ц+01.00-02.00 цагт багтаан байгуулж, шуурхай ажиллагааг Ц+00.30-02.00 цагт тушаалын 7 дугаар хавсралтад заасан "Шуурхай ажиллагаа зохион байгуулах журам", 2 дугаар хавсралтад заасан "Шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчийн ажиллах заавар"-ын дагуу зохион байгуулж эхэлнэ.

7.3. Ц+00.30-02.00 цагт Онцгой байдлын ерөнхий газрын бие бүрэлдэхүүн, шуурхай ажлын хэсгийг байнгын ажиллагаанд (24 цагаар) шилжүүлнэ.

7.4. Шуурхай штаб байгуулагдсан нөхцөлд бие бүрэлдэхүүн штабын мэдэлд ажлын тусгай горимд шилжиж үүрэг гүйцэтгэнэ.

7.5. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 9, 10 дугаар зүйлийн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газрын бие бүрэлдэхүүнийг нийтээр болон хэсэгчлэн гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлнэ. Онцгой байдлын ерөнхий газрын алба хаагчдын бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тушаалын загварыг /хавсралт 2/ хавсаргав.

7.6. Гамшгийн нөхцөл байдлын талаарх мэдээ, мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2008 оны 286 дугаар тушаалаар баталсан "Журам, заавар, бүлгийн бүрэлдэхүүн, жагсаалт батлах тухай" тушаалын 4 дүгээр хавсралтад заасан "Гамшгийн мэдээлэл солилцох бүдүүвч"-ийн дагуу зохион байгуулна.

7.7. Шуурхай удирдлагыг суурин(байнгын), хөдөлгөөнт удирдлагын байрнаас зохион байгуулна.

7.8. Шуурхай удирдлагыг 1 дүгээр суурин байрлал буюу Онцгой байдлын ерөнхий газрын төв байрны өргөтгөл /Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв/, 2 дугаар суурин байрлал буюу нийслэлийн иргэдийн "Гамшгаас хамгаалах сургалтын төв"-ийн байранд зохион байгуулна.

7.9. Шуурхай удирдлагын суурин байрлал ашиглах боломжгүй болсон нөхцөлд Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төвийн хөдөлгөөнт удирдлагын байр болон холбооны зангилгаа, Шуурхай штабын хөдөлгөөнт удирдлагын байрыг ашиглан зарлан мэдээллийг зохион байгуулна.

7.10. Шуурхай удирдлагын хөдөлгөөнт удирдлагын байр, Шуурхай удирдлага зарлан мэдээллийн төвийн хөдөлгөөнт удирдлагын байр болон холбооны

зангилгааг Үндэсний аврах бригадын байрлалд дулааны улиралд ил, хүйтний улиралд газар хөдлөлтийн 8-с доошгүй баллын чичирхийлэлт даах чадвар бүхий байгууламжид байнгын бэлэн байдалд байрлуулна.

7.11. Шуурхай бүлгийн бүрэлдэхүүний ажлын зардлыг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2011 оны 632 дугаар тушаалаар баталсан “Гамшгийн голомтод болон хойшлуулшгүй яаралтай ажилд томилон ажиллуулах журам”-ын дагуу шийдвэрлэнэ.

7.12. Шуурхай ажлын хэсэгт шаардлагатай автомашин ашиглах харилцааг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2008 оны 147 дугаар тушаалаар баталсан “Автомашин ашиглах журам”-ын дагуу зохицуулна.

7.13. Бодлого зохицуулалт, хамтын ажиллагааны газар нь газар хөдлөлтийн гамшгийн нөхцөл байдал үүссэн үед шаардлагатай шийдвэрийн төслийг бэлтгэн батлуулж, холбогдох нэгжүүдэд танилцуулах ажлыг хариуцна.

7.14. Гамшгийн шуурхай удирдлагын газар, Гал түймэртэй тэмцэх газрууд хөдлөлтийн гамшгийн нөхцөл байдал үүссэн үед эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, ажиллах бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг томилгоожуулах, тушаал шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах ажлыг хариуцна.

7.15. Үүссэн нөхцөл байдлыг нэгтгэх, зурагт оруулахад шаардлагатай байр зүйн зураг болон план зургаар Шуурхай штаб, Шуурхай ажлын хэсгийг хангах ажлыг Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв хариуцна.

7.16. Газар хөдлөлтийн гамшгийн нөхцөл байдал үүссэн үед шуурхай ажиллагааг хавсралт 11-т заагдсан болон бусад холбогдох эрх зүйн баримт бичгийн хүрээнд зохион байгуулна.

Найм. Зарлан мэдээлэл, холбоо зохион байгуулалт

8.1. Онцгой байдлын ерөнхий газрын бие бүрэлдэхүүнд газар хөдлөлтийн гамшгийн болон дадлага сургуулийн үеийн зарлан мэдээллийг Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвөөс Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/314 дүгээр тушаалаар баталсан “Онцгой байдлын ерөнхий газрын бие бүрэлдэхүүний зарлан мэдээллийн дохиогоор ажиллах журам”-ын дагуу Ц+00.00-02.00 цагт зохион байгуулна.

8.2. Онцгой байдлын ерөнхий газрын бие бүрэлдэхүүний утас, гэрийн хаяг, цахим хаягийг /хавсралт 1/ хавсаргав.

8.3. Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвөөс бие бүрэлдэхүүнд хөдөлгөөнт /үүрэн холбоо, утсан холбоо, сансрын холбоо, радио

холбоо, дотуур холбоо/ холбоо болон бие холбоочноор дамжуулж зарлан мэдээлэл хүргэнэ. Үүнд:

8.3.1. Газар хөдлөлтийн гамшгийн болон дадлага сургуулийн үед дохионы төрөл, гамшгийн төрөл, цугларах талбай, цаг хугацааг зааж, бие бүрэлдэхүүний үүрэн холбооны утас руу 156 тэмдэгтэд багтаан масс мессежээр зарлан мэдээлэл хүргэх. Жишээ нь:


- Ulaan kod – g.hudlult - OBEG jagsaalin talbai – 06:00 tsagt YARALTAI TSUGLAR

- Ulbar shar kod – g.hudlult – surgalt - UABrigad jagsaalin talbai – 06:00 tsagt TSUGLAR

- Shar kod – g.hudlult – surgalt - Morin toiruulga – 06:00 tsagt TSUGLAR

8.3.2. Бие бүрэлдэхүүнд утсан холбоогоор хавсралт 2-т заасны дагуу зарлан мэдээлэл хүргэх ба тухайн шатны алба хаагч гадаад, дотоодын албан үүрэгт ажилтай бол дараагийн шатны алба хаагчид зарлан мэдээлэл дамжуулах үүргийг өгнө.

8.3.3. Газар хөдлөлтийн гамшгийн болон дадлага сургуулийн үед радио торын аргаар холбоо зохион байгуулах бөгөөд удирдлагын холбоо, бүтцийн нэгжийн холбоо болон үндсэн холбоонд тогтоосон суваг, радио долгионы үелзлийг ашиглана.



Зураг 1. Радио холбоо зохион байгуулах бүдүүвч

- Радио станцын хэрэглэгчийн дуудлагыг Хавсралт 3-т заасанд үндэслэн Онцгой байдлын ерөнхий газрын бие бүрэлдэхүүнд харилцан ажиллагааны холбоо зохион байгуулалтын үед давхцахгүй байхаар ялгах үг, тооны нийлбэр хэлбэртэй

(Ерөө-1) байхаар баталж мөрдүүлнэ.

8.3.4. Газар хөдлөлтийн гамшгийн болон дадлага сургуулийн үед дотоод зарлан мэдээллийн төхөөрөмжөөр түгшүүрийн дохиог 30 секундэд үргэлжлэх хугацаатай 1 удаа дуугаргасны дараа шууд яриаг тодорхой давталттай явуулна.

8.3.5. Үүрэн холбооны сүлжээгүй орон зайд бие холбоочин нь сансрын холбоог ашиглан холбоо зохион байгуулна.

8.4. Газар хөдлөлтийн гамшгийн үед бүх төрлийн холбоо тасарсан тохиолдолд бүтцийн нэгж тус бүр зарлан мэдээллийн бүдүүвчийн дагуу, хоёроос доошгүй бие холбоочинг томилж, хавсралт 1-т заасан бие бүрэлдэхүүний мэдээллийн дагуу зарлан мэдээлэл хүргэнэ.



Зураг 2. Бие холбоочин ажиллуулах

8.5. Одон орон, геофизикийн хүрээлэнтэй газар хөдлөлтийн нөхцөл байдлын мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Одон орон геофизикийн хүрээлэнгийн захирлын 2016 оны 8 дугаар сарын 5-ний өдрийн өдрийн А/205, А/72.65 дугаар тушаалаар хамтран баталсан "Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх систем хоорондын харилцан ажиллагааг зохицуулах журам"-ын дагуу солилцоно. Уг журмыг /хавсралт 5/ хавсаргав.

8.5.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт 4 магнитудаас дээш газар хөдлөлт үүссэн тохиолдолд Монгол Улсын Шадар сайд, Шадар сайдын Онцгой байдлын асуудал

хариуцсан зөвлөх, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ахлах референт, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Онцгой байдлын ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд штабын дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга (2), Улсын Онцгой Комиссын нарийн бичгийн дарга, Гамшгийн шуурхай удирдлагын газрын дарга, ГШУЗМТөвийн дарга, Газар хөдлөлтийн тасгийн даргын үүрэн холбооны утас руу товч мэдээллийг техникийн бэлэн байдал хариуцсан инженер 160 тэмдэгтэд багтаан цаг алдалгүй хүргүүлнэ.

- 2017.06.11-ний удриин 22:15 tsagt Uvurkhangai aimgiin Bogd sumaas baruun zugt 55 km-t ml=4.1 huchtei gazar hudlult bolloo. OBEG

8.6. Иргэд, олон нийтэд зарлан мэдээлэл хүргэх үйл ажиллагааг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2019 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн А/68 дугаар тушаалаар баталсан “Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх заавар”-ыг мөрдлөг болгон ажиллана. Уг зааврыг /хавсралт 6/ хавсаргав.

8.7. Газар хөдлөлтийн гамшгийн болон дадлага сургуулийн үед үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран холбоог шуурхай, тасралтгүй зохион байгуулна. Холбоо зохион байгуулах журмыг урьдчилан тохирч дадлага, сургуулийг жил бүр хийсэн байна.

8.8. Онцгой байдлын ерөнхий газар нь холбооны тасралтгүй, найдвартай ажиллагааг хангахын тулд бүх төрлийн холбоо, мэдээллийн тоног төхөөрөмжийн зохих нөөцтэй байна. Нөөцийг төлөвлөгөөтэй бүрдүүлж, шинэчлэн сайжруулах арга хэмжээг Холбоо, техник, цахим мэдээллийн аюулгүй байдал хариуцсан бүтцийн нэгжтэй зөвшилцний үндсэн дээр Санхүү, хангалт, үйлчилгээний газар хариуцан зохион байгуулна.

РАДИО СТАНЦ ХЭРЭГЛЭГЧИЙН ДУУДЛАГА

д/д	Анги, байгууллагын нэр	Суваг	Радио дуудлага
Онцгой байдлын ерөнхий газар			
1	ОБЕГ-ын удирдлагууд болон бүтцийн нэгжийн дарга нар		Сүлд-11, 12, 13,
2	ОБЕГ-ын удирдлагуудын туслах		Мөрөн 11, 12, ...
3	ОБЕГ-ын холбооны суурин зангилгаа		Онцгой
4	ОБЕГ-ын төв байрны хариуцлагатай жижүүр		Төв
5	ОБЕГ-ын төв байрны шалган нэвтрүүлэгч байрны жижүүр		Шалган

6	ОБЕГ-ын төв байрны тавиулангийн жижүүр		Тавиулан
7	Гамшгийн шуурхай удирдлагын газар		Шуурхай-1, 2, 3,
8	Гал түймэртэй тэмцэх газар		Гал-1, 2, 3,
9	Гамшгаас урьдчилан сэргийлэх газар		ГУСГ-1, 2, 3, ...
10	Гамшгийн эрсдэлийн удирдлагын газар		Эрсдэл-1, 2, 3, ...
11	Захиргааны удирдлагын газар		Захиргаа-1, 2, 3, ...
12	Бодлого зохицуулалт, хамтын ажиллагааны газар		Бодлого-1, 2, 3, ...
13	Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газар		Нөөц-1, 2, 3, ...
14	Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газар		Санхүү-1, 2, 3, ...
15	Дотоод хяналт шалгалт, аюулгүй байдлын газар		Хяналт-1, 2, 3, ...

Ес. Нөөц

9.1. Шаардагдах санхүүгийн эх үүсвэр, багаж хэрэгсэл, нөөцийн бүртгэлийг тоон үзүүлэлтээр гаргаж дэлгэрэнгүй бичнэ /Хавсралт 10/.

9.2. Онцгой байдлын ерөнхий газрын төв байрны барилгаас алба хаагч, шаардлагатай эд зүйлсийг нүүлгэн шилжүүлэх тохиолдолд шаардагдах нөөцийг урьдчилж бэлтгэх.

9.3. Газар хөдлөлтийн гамшгийн улмаас гэртээ харих боломжгүй болох /зам хаагдах, гэр орон нуралтад өртсөн гэх.мэт/ нөхцөл байдал үүсч болох тул ийм нөхцөлд хэрэглэх ус, хүнсний нөөц, тээврийн хэрэгслийн хангалтыг зохион байгуулах талаар төлөвлөгөөнд тусгана.

9.4. Хүн хүч, техник хэрэгслийг дотоод нөөц боломж болон гэрээний үндсэн дээр бүрдүүлж, өөрчлөлт гарсан тохиолдол бүрт тодотгол хийн, шаардлагатай үед дайчлан ажиллуулна.Монгол улсын засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолын “Гамшгийн үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам”-ыг баримтлан ажиллана.

Арав. Хангалт зохион байгуулалт

10.1. Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газар, Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газар, гамшгийн нөхцөл байдал үүссэн үед шаардлагатай материал, хэрэгслээр хангах ажлыг хариуцан зохион байгуулна.

10.2. Шуурхай штаб, шуурхай ажлын хэсгийг шаардлагатай техник хэрэгсэл, холбоо, хүнс, шатах тослох материал, бэлэн мөнгөөр Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газар хариуцана.

10.3. Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газар, Үндэсний Аврах бригад, Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын байрлалд туулц сайтай автомашиныг холбооны болон бусад техник хэрэгслээр төхөөрөмжлөн нөөцөд байрлуулж, ашиглана.

10.4. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн тохиолдолд Шуурхай штабын байранд бичиг хэргийн материал, хоол хүнс, ус, эм хэрэгслийн 7 хоногийн нөөцийг бүрдүүлэх ажлыг Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газар зохион байгуулна.

10.5. Шаардлагатай тохиолдолд нөөцөд байгаа техник, багаж, хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас, хүнс, шатах тослох материал, бэлэн мөнгийг Шуурхай штаб, Шуурхай бүлгийн бүрэлдэхүүнд олгох ажлыг Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газар, Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн газар хамтран зохион байгуулна.

Арван нэг. Нүүлгэн шилжүүлэх

11.1. Нүүлгэн шилжүүлэлтийг зохион байгуулахдаа хариуцах бүлгүүд албан хаагчдын бүртгэл болон нэн шаардлагатай эд зүйлийн жагсаалт, нүүлгэн шилжүүлэх нөөц гарцын бүдүүвч зураг /хавсралт 7/, нүүлгэн шилжүүлэх гарцын чиглэл, /хавсралт 8/, урьдчилан бэлтгэсэн шилжин байрлах аюулгүй орчин бүхий хоргодох байр, гадна цугларах талбай /Хавсралт 9/, уг ажиллагааг зохион байгуулах хугацаа, оролцох хүмүүс, шаардагдах нөөц, хангалтыг тусгасан байна. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг мөрдлөг болгоно.

ТАНИЛЦСАН:

ТЭРГҮҮН ДЭД ДАРГА БӨГӨӨД ШТАБЫН ДАРГА, ХУРАНДАА	Ж.ЧҮЛТЭМСҮРЭН
ДЭД ДАРГА, ХУРАНДАА	Б.УУГАНБАЯР
ДЭД ДАРГА, ХУРАНДАА	Ц.ГАНЗОРИГ
ГАМШГИЙН ШУУРХАЙ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА	Б.МАНДАХГЭРЭЛ
ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА	Ц.НЯМБАЯР
ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА	А.АЛТАНБАГАНА

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА,
ХУРАНДАА Д.БААСАНСҮРЭН

ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГА, ХУРАНДАА Л.БОЛДБААТАР

БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ГАЗРЫН ДАРГА, ДЭД ХУРАНДАА Л.ӨЛЗИЙБАЯР

УЛСЫН НӨӨЦ, ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖИЙН
ГАЗРЫН ДАРГА, ДЭД ХУРАНДАА Ч.ЦОГБАЯР

САНХҮҮ, ХАНГАЛТ ХӨРӨНӨГӨ ОРУУЛАЛТЫН
ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА Я.ГАНТӨМӨР

ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,
ХУРАНДАА Г.БАТ-ЭРДЭНЭ

ХЯНАСАН:
ГАМШГИЙН ШУУРХАЙ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ТАСГИЙН ДАРГА, ХУРАНДАА Ж.ДАМДИНСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:
ГАМШГИЙН ШУУРХАЙ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
МЭРГЭЖИЛТЭН, ХОШУУЧ Б.ХИШИГБААТАР